



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/118 дугаар тушаалын Галиндэв овогтой Гүенд холбогдох хэсгийн “Калифорны их сургууль” гэснийг “Пеньсилвани мужийн их сургууль” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаалын хавсралт дахь Алзахгүй овогтой Баярчимэгт холбогдох хэсгийн “2 жил” гэснийг “3 жил” гэж, мөн тушаалын хавсралт дахь Батсайхан овогтой Өнөржаргалд холбогдох хэсгийн “1 жил” гэснийг “2 жил” гэж, мөн өдрийн А/115 дугаар тушаалын Ганзориг овогтой Энхзаяад холбогдох хэсгийн “3 жил” гэснийг “4 жил” гэж, мөн тушаалын хавсралт дахь Наранбат овогтой Эрдэмд холбогдох хэсгийн “4 жил” гэснийг “5 жил” гэж, 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/155 дугаар тушаалын Мягмарнаран овогтой Нямцэлмэгт холбогдох хэсгийн “4 жил” гэснийг “5 жил” гэж, мөн тушаалын хавсралт дахь Мягмарнаран овогтой Нямцэнгэлд холбогдох хэсгийн “4 жил” гэснийг “5 жил” гэж, мөн тушаалын хавсралт дахь Мөнхдалай овогтой Одончимэгт холбогдох хэсгийн “3 жил” гэснийг “4 жил” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/589 дүгээр тушаалын хавсралт дахь Лхагвасүрэн овогтой Уянга, 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/392 дугаар тушаалын хавсралт дахь Галбадрах овогтой Энхтуул нарын хүүхэд төрүүлж амаржсаны улмаас суралцаагүй 2 жилийг эрүүл мэндийн байгууллагаас олгосон баримт бичгийг үндэслэн гэрээг 2 жилээр тус тус сунгасугай.

142210411

3. Иргэдтэй зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Д.Гарди/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Ш.Нарантуяа/-т тус тус даалгасугай.

САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН